

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР
ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2024 оны 01 дүгээр
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөл нь Төрийн албаны тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан журам, зааврын хэрэгжилтийг системийн хэмжээнд хангах, түүнд хяналт тавих, төрийн алба хаагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалахад үндсэн үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

Нэг. Ерөнхий хэсэг.

1.1. Салбар зөвлөлийн үндсэн үйл ажиллагаа, төлөвлөгөө, зохион байгуулалтын ажил, үр дүн

Тус зөвлөл нь ШШГБ-ын хэмжээнд 2023 оныг “Байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах, аюулгүй байдал, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, алба хаагчийн хөгжлийг дэмжих” жил болгох зорилт, Төрийн албаны тухай хууль, холбогдох журам, заавар болон Төрийн албаны зөвлөлийн бодлого, шийдвэрт нийцүүлэн Салбар зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны 4 үндсэн арга хэмжээний хүрээнд 24 ажил, үйлчилгээ бүхий гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр батлан ажилласан.

Төрийн албаны зөвлөлийн бодлого, шийдвэр, тогтоол, журам, заавар, байгууллагын Салбар зөвлөлийн үйл ажиллагаа, хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн асуудал, хүний нөөцтэй холбоотой асуудлаар алба хаагчдад мэдээлэл хийж, ажлын байрны сул орон тооны зарыг байгууллагын вэб сайтад байршуулсан.

Салбар зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гарган, 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01/69, 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гарган, 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 01/1414 дүгээр албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, үйл ажиллагааны тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг ШШГЕГ-ын вэб хуудаст байрлуулан, бие бүрэлдэхүүн болон үйлчлүүлэгч-иргэдэд мэдээлэн сурталчилсан нь ил тод, нээлттэй байдлыг хангах нэг гол арга хэмжээ боллоо.

Байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцсэн хүний нөөцийг бэлтгэх, бэлтгэгдсэн хүний нөөцийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх давтан болон мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, мөн алба хаагчдын боловсролын түвшинг нэмэгдүүлэх зорилгоор гадаадын болон дотоодын их, дээд сургууль, удирдлагын академид элсэн суралцуулах зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд 2023 оны жилийн эцэст дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Сургалтын талаар:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 18-ний өдрийн А/215 дугаар тушаалаар батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад

2022-2023 онд зохион байгуулах чадавхжуулах сургалтын хөтөлбөр"-ийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих анги, салбар, нэгжид хүргүүлсэн.

Хорих анги, шийдвэр гүйцэтгэх газар, салбар нэгжүүд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагаас хүргүүлсэн сургалтын хөтөлбөрийн дагуу тухайн жилд зохион байгуулах хичээл, сургалтын төлөвлөгөөг өөрсдийн онцлогт нийцүүлэн боловсруулж, нэгжийн даргын тушаалаар батлуулан, сургалтыг зохион байгуулахыг үүрэг болгосон бөгөөд сургалтыг хэрхэн чанартай үр дүнтэй зохион байгуулах, тайлан мэдээг бичих талаар сургалт зөвлөгөөнийг хариуцсан мэргэжилтнүүдтэй цахимаар зохион байгуулахын зэрэгцээ мөн үүрэг чиглэл, зөвлөмж хүргүүлж удирдан чиглүүлсэн.

Сургалтыг цахим болон танхимаар лекц, семинар, дасгал ажил, хэлэлцүүлэг хэлбэрээр сургалтын хөтөлбөр төлөвлөгөөнд тусгасны дагуу дараах байдлаар зохион байгуулсан байна. Үүнд:

1.Шинээр батлагдсан хууль, журам заавар, нэмэлт өөрчлөлтийн талаар

Хорих анги, шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжүүд харьяа орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран танхимын сургалтыг дараах бүлэг сэдвүүдийн хүрээнд тайланд тодорхой тусгаж бичиж ирүүлсэн цагийг нэгтгэж үзвэл 642 цагийн сургалтыг зохион байгуулсан байна.

- Төрийн албаны тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль
- Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль
- Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль
- Эрсдэлийн үнэлгээг хийх аргачлал
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дотоод дүрэм, журам зэрэг
- Хүний эрх
- Жендерийн эрх тэгш байдал

2.Хувь хүний хөгжил, ёс зүй, хандлагыг дээшлүүлэх сургалт

Харьяа орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хувь хүний хөгжлийн чиглэлээр дараах бүлэг сэдвүүдийн хүрээнд танхимын сургалтаар тайланд тодорхой тусгаж бичиж ирүүлсэн цагийг нэгтгэж үзвэл 648 цагийн сургалтыг зохион байгуулсан байна.

- Баг, хамт олны хөгжил
- Стресс, түүний тухай ойлголт
- Архи согтууруулах ундааны хор нөлөө
- Ажлаас халшрах хам шинж
- Гэр бүлийн бат бэх харилцаа
- Эрүүл мэнд ЗХЖШ-ын даргын 2022 оны 02-р сарын 14-ний өдөр баталсан “Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчийн ёс зүй, бие бялдрын бэлтгэлжилтийг дээшлүүлэх хөтөлбөр” гэх мэт.

3.Алба хаагчийн бие бялдрын бэлтгэлжилт, норматив хангах болон Цэргийн албаны нийтлэг дүрэм, цэргийн хэргийн мэдлэг олгох сургалт

Нийт анги байгууллага ерөнхийлөгчийн нэрэмжит “Бие бялдрын бэлтгэлжилтийн түвшин тогтоох шалгалт”-тай холбогдуулан тайлангийн хугацаанд албаны бэлэн байдлыг шалган түргэн цугларах дохиогоор ажиллуулах, цэргийн дүрэмт хувцасны үзлэг болон аранзны үзлэг хийж, цэрэгжилч, жагсаалч байдлыг шалгаж, сургалт зохион байгуулах, цэргийн дүрмээр тестийн шалгалт авах ажлыг идэвхтэй зохион байгуулж, алба хаагчдаа бэлтгэж ажилласан байна.

4. Үндэсний Монгол бичгийн мэдлэгийг дээшлүүлэх сургалт

Үндэсний Монгол бичгийн сургалтыг идэвхтэй зохион байгуулж алба хаагчдын мэдлэгийн түвшинг тогтоож гэрчилгээ, батламж олгож ажилласан Хорих ял эдлүүлэх алба, 401, 413, 419, 429, 427, 433, 435, 439, 441, 445, 461 дүгээр нээлтэй, хаалттай хорих анги, Архангай, Баянхонгор, Дорноговь, Дорнод, Завхан, Сэлэнгэ, Төв, Увс, Хөвсгөл аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Сэлэнгэ аймгийн Сайхан сум, Дорноговь аймаг дахь Замын-Үүд сум дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс, СМДӨАЭАХХГ, “Хэрэмт цамхаг” УТҮГ, Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллага, Багануур дүүрэг дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсүүд байна.

5. Гадаад хэл мэдлэгийн түлхүүр сургалт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд гадаад хэлний сургалтын тогтолцоог байгууллагын чиг үүрэг, түүний онцлогтой уялдуулан бий болгох, алба хаагчдын мэргэжлийн англи хэлний ур чадварыг нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлагыг үндэслэн “Гадаад хэл-мэдлэгийн түлхүүр” 2020-2023 оны дунд хугацааны сургалтын хөтөлбөр”-ийг боловсруулан, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/42 дугаар тушаалаар батлан, хэрэгжилтийг хангаж ажилласан.

Зангиа академийн цахим сургалтаас англи хэлний хичээлийг сонгож судалсан байдал

Түвшин	Алба хаагчийн тоо	
	Эхний хагас жилийн байдлаар	Жилийн эцсийн байдлаар
Суурьгүй анхан шат	196	206
Суурьтай анхан шатны сургалт	134	143
Анхан дунд шат	70	78
Дунд шат	42	63
Ахисан дунд шат	28	28
Нийт	470	518

ШШГБ-ын алба хаагчдад зохион байгуулах албаны сургалтын хөтөлбөрт гадаад хэлний мэдлэг олгох сургалтыг жил бүр тусгаж хөтөлбөрийн хүрээнд нийт анги байгууллага, салбар нэгжүүд орон нутаг дахь гадаад хэлний сургалтын байгууллага, ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, төрийн бус байгууллагын багш нартай хамтран ажиллах гэрээ байгуулан, сургалтыг үргэлжлүүлэн зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллаж байгаа нь ахиц дэвшилтэй байна.

Алба хаагчдын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх, сургагч багш бэлтгэх чиглэлээр дараах анги, нэгжүүд алба хаагчдыг сургалтад хамруулж байна. Үүнд:

- Төв аймаг дахь ШШГГ-ын их эмч, ахлах дэслэгч А.Эрхболдыг 2023 оны 01 сараас Хуурай замын цэргийн командлалаас зохион байгуулж байгаа англи хэлний 06 сарын сургалтад ажлаас нь чөлөөлөн хамруулж, сургагч багшаар бэлтгэсэн.

Англи хэлний мэдлэг олгох сургалтыг танхимын хэлбэрээр зохион байгуулсан Хорих ял эдлүүлэх алба, 401, 421, 429, 437, 439, 445, 457 дугаар нээлттэй хаалттай хорих анги, Архангай, Дорнод, Говь-Алтай, Сэлэнгэ, аймаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Дорноговь аймаг дахь Замын-Үүд сум дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс, Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллага, СМДӨАЭАХХГ, Хэрэмт цамхаг Улсын төсөвт үйлдвэрийн газрууд байна.

Бусад анги байгууллагууд Зангиа академийн англи хэлний сургалтыг нийт алба хаагчдадаа судлах үүрэг чиглэл өгч биелэлтийг дүгнэн ажилласан байна. Тус цахим сургалтаар суурьгүй анхан шат болон суурьтай анхан шатны сургалтыг үзэж сертификат авсан тоо өссөн дүнтэй байгаа нь сайшаалтай байна.

Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 1, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацаанд давтан сургалтад 1, эрхэлсэн түшмэлийн багц сургалтад 1 алба хаагчийг тус тус хамруулж байна.

Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, алба хаагчийн мэргэжлийн манлайлал, ур чадвар, хандлагыг хөгжүүлэх зорилгоор ДХИС-ийн Удирдлагын академийн докторын өдрийн хөтөлбөрт 2, магистрын өдрийн хөтөлбөрт 12 алба хаагч;

ШШГАС-ийн докторын эчнээ хөтөлбөрт 6 удирдах ажилтан, ахисан шатны магистрын хөтөлбөрт 26;

ШШГАС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт 164, бакалаврын 3 жилийн эчнээ хөтөлбөрт 65, 5 жилийн эчнээ хөтөлбөрт 58 алба хаагч тус тус суралцаж байна.

Хууль зүй, дотоод хэргийн яам, Оросын Холбооны Улсын Дотоод хэргийн яам хоорондын хамтын ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд байгууллагын захиалгаар Москва хотын Удирдлагын академийн магистрантурт 4, бакалаврын хөтөлбөрт 24 нийт 28 алба хаагчийг тус тус суралцуулж байна.

Мөн байгууллагын захиалгаар дотоодын их дээд сургууль болох АШУҮИС-д 4, "Шинэ анагаах ухаан" их сургуульд 1, ШУТИС-ийн "Мэдээлэл, холбооны технологийн сургууль"-д 2 нийт 7 иргэн суралцаж байна. Суралцагсдын 2022-2023 оны хичээлийн жилд сургалтын төлбөрийг 100 хувь байгууллагаас олгож шийдвэрлэсэн.

1.2. Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэрийн хэрэгжилт, хуралдааны тэмдэглэлийг албажуулсан байдал:

Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөл нь батлагдсан "Хуралдааны дэг", "Ажил үүргийн хуваарь"-ийг мөрдөж байгаа бөгөөд байгууллагын цахим хуудсанд байршуулан иргэд, үйлчлүүлэгчдэд мэдээлэн сурталчилж ажиллаж байна.

Салбар зөвлөл нь хууль, журамд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 9 удаа хуралдан шаардлагатай цаг үеийн асуудлыг хэлэлцэж шийдвэрлэн ажилласан.

Хуралдааны хөтөлбөрийг урьдчилан гаргаж батлуулан, хуралдааны тэмдэглэлийг албажуулан, холбогдох материалуудыг нэгж болгон цэгцлэн ажиллаж ирсэн.

Салбар зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гарган, 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01/69, 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гарган, 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 01/1414 дүгээр албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, үйл ажиллагааны тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг ШШГЕГ-ын вэб хуудаст байршуулсан.

Салбар зөвлөлийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан.

2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01/249, 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 01/2147 дугаар албан бичгээр Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулах саналыг хүргүүлсэн.

Энэхүү саналтай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 43 дугаар тогтоолоор өөр албан тушаалд томилогдсон нэр бүхий 3, 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 464 дүгээр тогтоолоор 1 алба хаагчийг салбар зөвлөлийн гишүүнээс чөлөөлүүлж, шинээр холбогдох алба хаагчдыг томилуулсан.

Тайлангийн хугацаанд Салбар зөвлөлд ирүүлсэн өргөдөл гомдол байхгүй.

Төрийн албаны тухай хуульд нийцүүлэн Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор батлагдсан журам, зааврыг алба хаагчдад мэдээлэн сурталчилж судлуулах, хүний нөөцийн холбогдолтой асуудлыг шийдвэрлүүлэхээр ШШГЕГ-т уламжлахдаа анхаарах зарим асуудал зэргээр тодорхой үүрэг чиглэлийг анги, нэгжийн удирдлага, хүний нөөц, хэвлэл мэдээлэл, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн нарт өгч, биелэлтийг хангуулж ажилласан.

Хоёр: Үндсэн хэсэг:

2.1. Хууль, журам, заавар, төрийн албаны стандартын хэрэгжилтэд хяналт шалгалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байдал, үр дүн

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа анги, нэгжийн үйл ажиллагаанд төрийн хууль тогтоомжийн хэрэгжилт, алба хаагчдын сахилга, хариуцлага, байгууллагын болон төрийн алба хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний төлөвлөлт, биелэлт, хүний нөөцийн бодлогын бичиг баримт, хувийн хэргийн бүрдүүлэлт, цахим системийн хөтлөлт зэрэг бүх л талын ажлыг хянан шалгах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хуваарийг батлан мөрдүүлж ажилласан.

ШШГБ-ын 2022 оны үйл ажиллагааны үнэлгээний мөрөөр дүгнэлт, зөвлөмж боловсруулж харьяа алба, газар, хэлтэст 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 01/260-01/264 дүгээр албан бичгээр тус тус хүргүүлсэн.

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд 4 зорилтын 15 арга хэмжээг хэрэгжүүлж, 93.33 хувьтай, өмнөх онд үнэлэгдсэнээс 24 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Бодлогын баримт бичгийн 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн үнэлгээний тайланг 2023.06.05-ны өдрийн 01/1243, 2023 оны жилийн эцсийн тайланг 2023.12.11-ний өдрийн 02/2609 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүллээ. ХЗДХЯ-ны өгсөн чиглэлийн дагуу 2023 оны эхний хагас жилийн тайланг www.unelgee.gov.mn цахим санд тайлагнасан болно.

“Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хүрээнд 5 зорилтын 9 арга хэмжээг хэрэгжүүлж, 2023 оны жилийн эцсийн байдлаар 91.6 хувьтай үнэлэгдэж, өмнөх оны мөн үеэс 12.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар 98.8 хувьтай үнэлэгдлээ.

Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хүрээнд ШШГБ-ын 100 сая мод тарих хөтөлбөр, цахим шилжилтийн талаарх ажлын 2022 оны хэрэгжилтийг гарган 2023.01.06-ны өдөр цахим хэлбэрээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн.

“Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд 2 зорилтын 2 арга хэмжээг хэрэгжүүлж, 2023 оны хэрэгжилт 100 хувьтай үнэлэгдсэн.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн байдлаар 98.8 хувь, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31 хувиар өссөн үзүүлэлттэй.

-Дархан-Уул аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-445 дугаар нээлттэй хорих ангид 2023 оны 05 дугаар сарын 03-06-ны өдрүүдэд төлөвлөгөөт хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж, тайланг боловсруулан ажилласан бөгөөд 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 07/1114 дүгээр албан бичгээр хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр зөвлөмжийг хүргүүлсэн.

-“Хэрэмт цамхаг” УТҮГ -ын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн, мөн 2023 оны 11 дүгээр сард Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Банкны төлбөр барагдуулах газрын өргөдөл, гомдол шийдвэрлэх үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, түүний мөрөөр ажил сайжруулах үүргийн өгсөн.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудагт байршуулсан мэдээлэлд сар бүр хяналт тавьж, улирал бүр тайланг нэгтгэн 2023 оны 1 дүгээр улирлын тайлангийн мэдээлэл байршуулах үйл ажиллагаа 95.7 хувьтай дүгнэгдэж, тайланг 04 дүгээр сарын 26-ны өдрийн 07/927, дугаар албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн. 2023 оны 2, 3 дугаар улирлын тайланг шилэн дансны цахим хуудагт оруулж, ХЗДХЯ-нд тайлагнасан.

“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллах зорилгоор 2023.02.10-ны өдрийн 07/362, 2023.04.26-ны өдрийн 07/928, 2023.05.31-ний өдрийн 07/1223, 2023.08.16-ны өдрийн 07/1684 дүгээр албан бичгээр 4 удаагийн үүрэг, мөн 4 удаагийн зөвлөмжийг алба, хорих анги, байгууллагуудад хүргүүлж ажилласан.

“Хөндлөнгийн үнэлгээ” хийлгэхээр сонгон шалгаруулалт явуулж, “Оюуны цэлмэлт” нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээг байгуулж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 2023 оны хэрэглэгчийн үнэлгээ 95.4 хувь буюу 4.77 оноотой дүгнэгдсэн.

2.2.Төрийн жинхэнэ албанд ажиллах хүний нөөцийг сургаж бэлтгэх, нөөц бүрдүүлэх, томилогдох ажилтны сонгон шалгаруулалт, нэр дэвшүүлсэн ажиллагаа ил тод, нээлттэй байдлыг хангасан байдал, үр дүн

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн сул орон тоог нөхөх, нөөц бүрдүүлэх зорилгоор сонгон шалгаруулалтын зарыг мэдээлж, ажилд орох хүсэлт гаргасан иргэдийг бүртгэж, журамд заасан болзол шаардлага, тухайн албан тушаалд тавигдах ерөнхий ба тусгай шаардлагад нийцүүлэн сонгон шалгаруулалтыг явуулж, ДХИС-ийн Ахлагчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн "Харуул хамгаалалтын албаны ажилтан" бэлтгэх сургалт, "Офицер" бэлтгэх дамжаанд хамруулж, тэнцсэн иргэдийг албан тушаалд томилон ажиллаж байна.

Ахлагчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн "Харуул хамгаалалтын албаны ажилтан" бэлтгэх сургалтыг 3 удаа, "Офицер" бэлтгэх дамжааг 2 удаа, ШШГБ-ын цэргийн хэргийн мэдлэг олгох сургалтыг 2 удаа тус тус зохион байгуулж, шаардлага хангасан иргэдийг албан тушаалд томилсон.

Мөн шийдвэр гүйцэтгэгчийн нөөц бүрдүүлэх зорилгоор "Шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт"-ыг 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдөр явуулж, сорилын болон ярилцлагын шалгалтад тэнцсэн 33 оролцогчийг Орон тооны бус мэргэжлийн комиссоос шалгалтын дүнг баталгаажуулж, шийдвэр гүйцэтгэгчийн нөөцөд бүртгэсэн.

Байгууллагын сул орон тоог нөхөх зорилгоор ОХУ-ын ДХЯ-ны харьяа их, дээд сургууль, ДХИС-ийн ШШГА-ны сургууль, Ахлагчийн сургууль төгсөгчид болон шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэд, ажиллаж байгаа алба хаагчдаас нөөц бүрдүүлэлтийг зохион байгуулан ажиллаж байна. Оросын Холбооны Улсын Удирдлагын академийн докторын хөтөлбөрт хамрагдаж төгссөн 1, магистрын хөтөлбөрийг төгссөн 2, Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн магистрын хөтөлбөрийг төгссөн 3, тус сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн "Шүүхийн шийдвэр гүйцэтгэл-эрх зүй" бакалаврын хөтөлбөрийг төгссөн 32, эчнээ хөтөлбөрийг төгссөн 18 алба хаагчийг албан тушаалд тус тус томилсон.

Мөн Дотоод хэргийн их сургуулийн Ахлагчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн ШШГА-ны "Офицер" бэлтгэх сургалтыг төгссөн 22, "Харуул хамгаалалтын албаны ажилтан" бэлтгэх сургалтыг төгссөн 205 алба хаагчийг тус тус томилсон.

2023 оны жилийн эцсийн байдлаар ШШГЕГ-ын даргын тушаалаар 376 иргэнийг шинээр, 322 алба хаагчийг албан тушаалд дэвшүүлэн, 350 алба хаагчийг шилжүүлэн томилсон.

Нэгжийн даргын тушаалаар 174 алба хаагчийг шилжүүлж, 302 иргэнийг шинээр томилсон байна.

Харьяа хорих анги, салбар нэгжүүд нь тухайн орон нутгийн Хилийн болон Дотоодын цэргийн ангиуд, политехникийн коллеж болон Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн сурагчдад байгууллагын үйл ажиллагаа, онцлог давуу талууд болон ДХИС-ийн Ахлагчийн сургуулийн талаар танилцуулга мэдээллийг тус тус хүргэж ажилласан.

Нэн шаардлагатай албан тушаалын сул орон тооны мэдээллийг болон ажилд орох хүсэлтэй иргэдэд тавигдах шаардлага, бүрдүүлэх материалын жагсаалт зэргийг байгууллагын цахим хаягт байршуулдаг.

Байгууллагын хүний нөөцийн сул орон тоог нөхөх, нөөц бүрдүүлэх зорилгоор Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн 5 тогтоолоор 320 төгсөгчийг нөөцөд бүртгэж ажилласан. Үүнд:

-2023.02.13-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор ДХИС-ийн Ахлагчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн "харуул хамгаалалтын албаны ажилтан" мэргэжлийн дамжаа төгссөн-70,

-2023.05.18-ны өдрийн 06 дугаар тогтоолоор ДХИС-ийн Ахлагчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн "харуул хамгаалалтын албаны ажилтан" мэргэжлийн дамжаа төгссөн-94,

-2023.05.26-ны өдрийн 07 дугаар тогтоолоор Байгууллагын үйл ажиллагааны онцлог, цэргийн хэргийн мэдлэг олгох сургалт төгссөн-23,

-2023.06.23-ны өдрийн 10 дугаар тогтоолоор ДХИС-ийн ШШГА-ны сургуулийн "шүүхийн шийдвэр гүйцэтгэл-эрх зүй" мэргэжлийн бакалаврын сургалт төгссөн-48 ,

-2023.12.07-ны өдрийн 13 дугаар тогтоолоор ДХИС-ийн Ахлагчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн "харуул хамгаалалтын албаны ажилтан" мэргэжлийн дамжаа төгссөн-85

Өмнөх оны нөөцөд бүртгэлтэй ДХИС-ийн ШШГА-ны сургуулийн бакалаврын хөтөлбөрийг төгссөн 2 сонсогч, эчнээ хөтөлбөрийг төгссөн 13 алба хаагч, Ахлагчийн сургуулийг төгссөн 57, шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн 30 иргэнээс нөөц бүрдүүлэлтийг зохион байгуулан ажиллаж байна.

Алба хаагчдын шилжилт хөдөлгөөний талаар:

2023 оны жилийн эцэст хийгдсэн алба хаагчдын шилжилт хөдөлгөөнийг 2022 оны мөн үетэй харьцуулахад ШШГБ-д шинээр томилогдсон алба хаагчийн тоо 23.4 дахин өссөн, дэвшин томилогдсон алба хаагчийн тоо 9.8 хувиар, шилжсэн алба хаагчийн тоо 6.2 хувиар, албан тушаал буурсан алба хаагчийн тоо 1.2 дахин, тэтгэвэрт гарсан алба хаагчийн тоо 5.2 хувиар, ажлаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн алба хаагчийн тоо 17.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Алба хаагчдын шагнал урамшууллын талаар:

2023 оны жилийн эцсийн байдлаар Төрийн дээд шагналаар 199, Хууль зүй, дотоод хэргийн яамны шагналаар 502, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шагналаар 738, мөнгөн шагнал урамшууллаар 644, анги, нэгжийн шагнал, урамшууллаар 2380, бусад байгууллагын шагналаар 270, нийт 4733 алба хаагч шагнагдсан байна.

Алба хаагчдын гаргасан сахилгын зөрчлийн талаар:

2023 оны жилийн эцсийн байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй хандаж, сахилгын зөрчил гаргасан 130, Хорих анги, Шийдвэр гүйцэтгэх алба, салбар нэгжийн даргын тушаалаар 540, нийт 670 алба хаагчдад сахилгын шийтгэл ногдуулсан нь нийт алба хаагчдын 20.7 хувийг эзэлж байна.

"Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ыг мөрдөн ажиллаж удирдлагаас гаргасан тушаал, шийдвэр болон алба хаагчийн, чөлөөлөгдсөн, тэтгэвэрт гарсан, шилжүүлэн томилсон нийт 40135 хуудас материалыг хувийн хэрэгт баяжилт хийж, шинээр албан тушаалд томилогдсон 338 алба хаагчийн хувийн хэргийг нээн товъёг хөтөлж, харьяа газар, анги, салбар нэгжид байршуулсан.

Албан тушаалаас чөлөөлөгдсөн, тэтгэвэр тогтоолгохоор чөлөөлөгдсөн, халагдсан, нас барсан, бусад байгууллагын мэдэлд шилжүүлсэн зэрэг нийт **301** алба хаагчийн хувийн хэрэгт баяжилт хийж, Тусгай архивд шилжүүлсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь төрийн цэргийн байгууллага болсонтой холбогдуулан Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3.ё-д “төрийн цэргийн байгууллагын бие бүрэлдэхүүний тоо бүртгэл, бэлтгэл үүрэгтэн, цэрэгт татах болон цэргээс халагдах хүмүүсийн нэгдсэн мэдээлэл, цэргийн мэргэжлийн ангилал, оногдуулан данслагдсан хүн, техникийн нэгдсэн дүн, тооцоо /улсын болон нийслэл, аймгийн хэмжээнд/ нууцад хамаарна” гэж заасны дагуу Төрийн албаны “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системээс хасуулах ажлыг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагуудад саналаа хүргүүлээд байна.

Төрийн албаны зөвлөлийн “7:4:10” арга зүйн сургалтад харьяа алба, хорих анги, газар, салбар нэгжийн алба хаагчдыг тогтмол хамруулах талаар анхааран ажилласан ба нийт 20 удаагийн сургалтад хамруулсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд 2023 оныг “Байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах, аюулгүй байдал, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, алба хаагчийн хөгжлийг дэмжих” жил болгон зарласан. Тус зорилтын хүрээнд:

- 1.Цахимжуулах ажлыг эрчимжүүлж, төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх боломжийг нэмэгдүүлэх;
2. Байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хангаж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх менежментийг бэхжүүлэх;
- 3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх зүйн орчинг сайжруулж, алба хаагчийн эрх зүй, нийгэм, эдийн засгийн баталгааг хангах;
- 4.Хүний нөөцийн удирдлагыг оновчтой зохион байгуулж, тогтвор суурьшилтай ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх;
- 5.Алба хаагчийн хэрэгцээ шаардлагад суурилсан сургалтын арга хэлбэрийг нэвтрүүлж, мэргэшсэн чадварлаг хамт олныг төлөвшүүлэх;

Тайлангийн хугацаанд дээрх зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Цахимжуулах ажлыг эрчимжүүлж, төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх боломжийг нэмэгдүүлэх;

Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн, чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж, хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан, үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль, тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт, албан тушаалтны овог, нэр, харилцах утасны дугаар, цахим шуудангийн хаяг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, статистик мэдээ, зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр, ажлын байрны сул орон тооны мэдээлэл,

албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам, ёс зүйн дүрэм, хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам, үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалт болон үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, үйл явдлын мэдээ мэдээллийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын www.cd.gov.mn цахим хуудаст холбогдох линкийг байршуулан, иргэд, олон нийтийн мэдээ, мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлсэн.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд 68 төрлийн мэдээллийг ил тод, нээлттэй болгохоор заасан ба мэдээллийг ил тод болгосон эсэхийг тодорхойлох 98 шалгуур үзүүлэлтийн дагуу холбогдох мэдээллүүдийг cd.gov.mn цахим хуудаст байршуулж, хэрэгжилтийг Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн бөгөөд тус яамны <https://shilen.gov.mn/> сайтад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар **98.70** хувиар үнэлэгдэж, агентлагуудаас долдугаар байрт жагсаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын www.cd.gov.mn сайтад 156, фэйсбүүк хуудаст 325, дотоод мэдээллийн самбарт 68 мэдээ мэдээллийг тус тус байршууллаа. Цахим хуудаст давхардсан тоогоор 178568 удаагийн хандалт хийгдсэн байна.

Байгууллагын албан ёсны cd.gov.mn сайтад шаардлагатай цэсийг нэмж, баяжилт хийх хүрээнд “Төрийн мэдээлэл” цэсэнд эмхэтгэлийн 41 дугаар, “Албадан дуудлага худалдаа” цэсэнд 20 зарыг тус тус нэмэлт цэс үүсгэж байршуулсан.

Мөн Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 96 дугаар тогтоолын хавсралт “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-т заасны дагуу байгууллагын цахим хуудаст нийтэлж байгаа мэдээг крилл, монгол бичгээр хослуулан хөрвүүлж байршуулж хэвшсэн.

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага” фэйсбүүк хуудасны дагагч 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 47023 байгаа бөгөөд тус тоон үзүүлэлтийг өмнөх оны жилийн эцсийн байдалтай харьцуулахад 6415 дагагчаар нэмэгдсэн.

Мөн байгууллагын фэйсбүүк хуудасны онлайн чатаар хандсан **1453** иргэнд хорих ял эдлүүлэх үйл ажиллагаа, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа, сургалтын чиглэлээр асуусан асуултад мэдээлэл өгөх албан тушаалтныг холбон тухай бүрт нь хариу өгч ажилласан.

Мэдээ мэдээллийн агуулга, хүртээмж, ач холбогдлыг сайжруулах, гарч болохуйц сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх зорилгоор харьяа анги, байгууллага, салбар, нэгжийн хэмжээнд бэлтгэн түгээж буй мэдээ мэдээлэл, контент, нэвтрүүлэг, постер, шторк зэргийг урьдчилан хянаж, редакторлан, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, нийтлэх зөвшөөрөл өгч хэвшүүлсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар нь нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор албан ёсны www.cd.gov.mn цахим хуудас, олон нийтийн сүлжээний @courtdecision цахим хаяг, харьяа хорих анги, шийдвэр гүйцэтгэх газар нэгжийн нийт 57 цахим хуудсаар дамжуулан мэдээ, мэдээллийг түгээдэг.

Байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хангаж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх менежментийг бэхжүүлэх;

Байгууллагын аюулгүй байдлыг хангаж аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 04:00-05:00 цагийн хугацаанд Төв байр болон Хорих ял эдлүүлэх байрны гэрэлтүүлэг, өрөөний лац, телекамер, галын хор, цонх, автомашины гараж, томилгоот алба хаагчийн үүрэг гүйцэтгэлтийг шалгаж, эрсдэлийн үнэлгээ хийж бага эрсдэлтэй гэсэн дүгнэлт гаргасан. Дээрх эрсдэлийн үнэлгээнд хариу арга хэмжээг авч ажиллах талаар зохион байгуулалтын дараах арга хэмжээг авч ажилласан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хяналт шалгалт, аюулгүй байдлын газрын даргын удирдамж, хуваарийн дагуу Аюулгүй байдал, тусгай ажиллагааны хэлтсийн дарга, хурандаа Ж.Цэрэн-Отгон, ахлах мэргэжилтэн, хошууч Ш.Нямсүрэн, СҮХОГ-ын ҮБТХ-ын ГХАБЭА-ын мэргэжилтэн, хошууч Х.Эрдэнэсайхан, аюулгүй байдал хариуцсан ахлах байцаагч, ахмад П.Алтанхуяг нарын нийт 4 алба хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр 2023 оны 4 дүгээр сарын 26, 27, 28-ны өдрүүдэд Гамшгийн үед ажиллах төлөвлөгөө, тог цахилгааны хэвийн үйл ажиллагаа, барилга, байгууламж, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, галын аюулгүй байдлын чиглэлээр тус тус шалгах хуудас, тухайн орон газар, байршил дээрх биечилсэн үзлэг, шалгалтыг хийж хариуцсан алба хаагчдад илэрсэн зөрчил, дутагдлын талаар тайлбарлаж, зөрчлийг арилгах чиглэлээр зааварчилгаа өгсөн ба үзлэг шалгалтад Улаанбаатар хотын хүрээний алба, анги, шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн нийт 19 салбар хамрагдсан илэрсэн зөрчлийг талаар арилгах тухай хугацаатай үүргийг хүргүүлж ажилласан.

Мөн Баян-өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын барилга, байгууламж, алба хаагчийн аюулгүй байдлыг хангаж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийлгэж, тус газрын барилгын дээврийн таазны нуруу мод хуучирсан, хана таазанд цууралт өгсний улмаас нуралт үүсэх эрсдэлтэй, барилгын цахилгааны утаснууд хуучирч, муудсан цахилгааны холболт стандартын шаардлага хангахгүй гэж гарсан ба Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 10.000.000 төгрөг шийдвэрлүүлсэн байна. 421 дүгээр нээлттэй хорих анги, Дархан-Уул аймаг дахь ШШГГ-445 дугаар нээлттэй хорих анги, ШТН ТӨААТҮГ, Өвөрхангай аймаг дахь ШШГГ, Өмнөговь аймаг дахь ШШГГ, Завхан аймаг дахь ШШГГ, Сүхбаатар аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрууд тус тус эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн байна.

ЗХЖШ-ын даргын 2022 оны А/65 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчийн ёс зүй, бие бялдрын бэлтгэлжилтийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрмийг мөрдүүлэх, цэвэр үзэмжтэй соёлтой хэрэглээг хэвшүүлэх зорилгоор байгууллагын хэмжээнд “Дүрэмт хувцас бидний бахархал, Дүрмээр өмсөх бидний үүрэг” аяныг зохион байгуулан холбогдох видео, шторк, уриалгыг бэлтгэн байгууллагын вэб сайтад байршуулсан.

2023.01.04-нд ШШГЕГ-ын төв, ХЯЭА-ны байрны аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээ хийж учирч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 1 давхрын 14 цонхонд төмөр сараалжин хамгаалалтын тор, шөнийн цагаар гадна орчны үзэгдэх байдлыг нэмэгдүүлэх зорилгоор 2 хэсэгт гэрэлтүүлэг, 3 хэсэгт телекамер, 7 байрлалд 22 ширхэг галын хорыг нэмж байршуулан төв байрны аюулгүй байдлыг хангуулах ажил зохион байгуулсан. Баривчлах төвийн өдөр тутмын үйл ажиллагаа, аюулгүй байдал, харуул хамгаалалт болон баривчлагдсан, албадан эмчлэгдэж байгаа этгээдэд үзүүлж буй эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, архины хамаарал бүхий этгээдийн эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2023.02.18-нд эрсдлийн үнэлгээ хийж улмаар

2023.02.20-нд цаашид авч хэрэгжүүлэх ажил арга хэмжээний талаарх зөвлөмжийг хүргүүлж биелэлтэд хяналт тавьж ажилласан.

Үйлдвэр, аж ахуй, барилгын хэлтсийн өдөр тутмын үйл ажиллагаа болон харуул хамгаалалт, хоригдлын эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдал, техник, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, бүрэн бүтэн байдал, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд эрсдэлийн үнэлгээг 2023.08.10-нд хийж илэрсэн зөрчлийг арилгах, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч ажиллах, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх тухай зөвлөмжийг 2023.08.17-нд хүргүүлж биелэлтийг хангуулан ажилласан.

Төв аймаг, Мөнгөн морьт сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-417 дугаар нээлттэй хорих ангид 2023.10.02-05-ны өдрүүдэд эрсдэлийн үнэлгээг хийж 2023.10.07-нд зөвлөмж хүргүүлсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх зүйн орчинг сайжруулж, алба хаагчийн эрх зүй, нийгэм, эдийн засгийн баталгааг хангах;

ХЗДХС-ын 2022 оны А/71 дүгээр тушаалаар “Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн төсөл боловсруулах “Ажлын хэсэг”-ийг байгуулсан. Уг ажлын хэсгийн чиг үүргийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор ШШГЕГ-ын даргын 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн А/95 дугаар тушаалаар 11 алба хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр “Дэд ажлын хэсэг”-ийг байгуулсан.

Дэд ажлын хэсгээс хуулийн төслийн хэрэгцээ шаардлагын тандан судалгаа, зардлын тайлан, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан зэрэг нийт 3 төрлийн судалгаа болон шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдал, гүйцэтгэх баримт бичигт тавигдах шаардлага, хөрөнгө албадан худалдан борлуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалтын санал боловсруулж “Ажлын хэсэг”-т хүргүүлсэн.

Мөн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор гадаад улс орны ижил чиг үүрэг бүхий байгууллагын тогтолцоо, онцлогийн талаарх судалгааг Хууль зүйн Үндэсний хүрээлэнтэй байгуулсан гэрээний дагуу гүйцэтгүүлж, судалгааны ажлыг “Ажлын хэсэг”-т танилцуулсан болно.

Хуулийн төсөл боловсруулах үйл явцтай холбогдуулан шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлт, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, шүүхэд маргаан хянан шийдвэрлэсэн хугацаа, тоон үзүүлэлт болон алба хаагчдын ажлын ачааллын дэлгэрэнгүй судалгааг гарган хүргүүлээд байна.

“Шүүхийн шийдвэрийн биелэлтэд нөлөөлж буй хүчин зүйлс, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” хэлэлцүүлгийг 2023 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулсан.

Уг хэлэлцүүлгээр шүүхийн шийдвэрийн биелэлтэд эрх зүйн зохицуулалт, чиг үүрэг хэрэгжүүлэх тогтолцоо, албан хаагчдын ажлын ачаалал, төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн төлбөрийн чадвар зэрэг хүчин зүйл нөлөөлж буйг онцлон цаашид боловсон хүчнийг тогтвортой ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх, тэтгэлэг, төлбөр авагч иргэдийн хууль ёсны эрх, ашгийг шуурхай хангахын тулд ажлын ачааллын жишиг нормативыг шинэчлэх, албадлагын арга хэмжээний үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор холбогдох хууль, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг гаргаж, Иргэний болон Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх тухай хуулийн

төсөлд тусгуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэхээр боловсруулж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ахлагч бүрэлдэхүүнийг албан тушаалд томилох, чөлөөлөх, түр чөлөөлөх, халах, хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу цэргийн цол олгох, сэргээх, бууруулах, хураан авах эрхийг ШШГЕГ-ын даргын 2023 оны А/10 дугаар тушаалаар харьяа алба, хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжийн дарга нарт шилжүүлж, холбогдох журмыг баталсан.

ХЗДХС-ын 2023 оны А/22 дугаар тушаалаар “Албан тушаалын ангилал, цолны зэрэглэл”-ийг шинэчлэн батлуулсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 10-ны А/85 дугаар тушаалаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-д нэмэлт өөрчлөлтүүдийг тус тус оруулсан. Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль, Цэргийн албаны тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлттэй холбогдуулан ШШГЕГ-ын төв байр болон тусгай нэгжийн алба хаагчдын ажилласан жилийн хугацааг нэмэгдүүлэн олгох тухай хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөмж боловсруулж ШШГЕГ-ын даргын 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 01/355 дугаартай албан бичгээр Нийгмийн даатгалын газартай хамтран ажиллах тухай зөвлөмжийг хүргүүлж хамтран ажиллаж байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын өгсөн үүргийн дагуу таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан этгээдэд хяналтын тоног төхөөрөмж буюу цахим бугуйвч ашиглан хяналт тавихад холбогдох хууль, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах санал, хяналт тавих ажиллагааны зардал төсөв, бүтэц орон тоо, хүний нөөцийн талаарх танилцуулга боловсруулах зорилгоор Дотоод хэргийн их сургуулийн Сургалт эрдэм шинжилгээний газрын Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвтэй хамтран ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

Хүний нөөцийн удирдлагыг оновчтой зохион байгуулж, тогтвор суурьшилтай ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх;

Хүний нөөцийн бүрдүүлэлт, нөхөн хангалтыг нэмэгдүүлэх зорилгоор ШШГЕГ-ын даргын 2023 оны А/10 дугаар “Захиргааны эрх шилжүүлэх тухай” тушаалаар “Ахлагч бүрэлдэхүүний томилгоо, шилжилт хөдөлгөөнийг зохицуулах журам” батлагдаж, ахлагч бүрэлдэхүүний томилгоо, шилжилт хөдөлгөөний асуудлыг нэгжийн үйл ажиллагаанд шилжүүлсэн.

Ахлагч бүрэлдэхүүний шилжилт хөдөлгөөний зохион байгуулалттай танилцах удирдамжийн хүрээнд 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдрөөс 2023 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийг дуустал хотын бүсийн хорих анги, салбар нэгжид Хүний нөөцийн хэлтсийн алба хаагчид журмын хэрэгжилттэй танилцаж, холбогдох заавар, зөвлөгөөг өгч ажилласан.

Нэгжийн даргын тушаалаар хийгдсэн шилжилт хөдөлгөөний мэдээг 7 хоног бүр авч, нэгтгэн ажиллаж байна.

ШШГБ-ын Ахлагч бүрэлдэхүүний томилгоо, шилжилт хөдөлгөөнийг зохицуулах журмын хэрэгжилтийн хүрээнд нэгжийн хүний нөөц хариуцсан ажилтнуудыг тогтмол мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан эх оронч үзэл төлөвшүүлэх зорилго бүхий “Бидний бахархал” төслийг Чингэлтэй дүүргийн 149, 72, 37, 49, 117, 5, 50, 23, 24, 17, 39, 57, 61 дүгээр ерөнхий боловсролын сургуулиудад зохион байгууллаа. Үйл ажиллагааны үеэр Монгол Улсын гавьяат багш, доктор, профессор, бэлтгэл хурандаа Б.Галиндэв, Үндэсний батлан хамгаалах их сургуулийн Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэнгийн цэргийн түүхийн төвийн дарга, доктор, хошууч Т.Сүхбаатар нар эх оронч үзэл, тусгаар тогтнол, эрх чөлөөний талаар лекц уншиж, сурагчдад мэдээлэл өгснөөс гадна сонирхсон асуултад нь хариулсан. Мөн “Монгол цэргийн музей”, “Мөнхөд дурсагдах баатрууд” ТББ-ын үзмэрүүдийг дэлгэсэн бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа “Соёмбо чуулга”-ын уран бүтээлчид урлагийн номерыг тус тус толилуулж, хүүхэд, залуучуудад “Тусгаар тогтнол” сэдэвт 12 минутын видео контентыг үзүүлэн ажиллалаа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын “Хүний нөөцийн бодлогын хөгжлийг бэхжүүлэх 2020-2024 оны дунд хугацааны хөтөлбөр”-ийн хэрэгжилт 78 хувьтай байгаа бөгөөд тус хөтөлбөрийн хүрээнд ШШГБ-ын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, эрх зүйн орчинг бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, хөгжүүлэх, нийгмийн баталгааг сайжруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна.

Алба хаагчдын нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг хангах зорилгоор 2023 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нийт алба хаагчдын цалинг 2023 оны 10 дугаар сараас нэмэгдүүлэх ажлыг дотооддоо зохион байгуулж, офицер бүрэлдэхүүнийг нэг, ахлагч бүрэлдэхүүнийг хоёр шатлалаар тус тус нэмэгдүүлэх саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/335 дугаар тушаалаар шийдвэрлүүлсэн.

Аймгийн төвөөс алслагдсан нутаг дэвсгэрт байрлах шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих анги, салбар нэгжийн алба хаагчдад тасралтгүй ажилласан 5 жилийн урамшуулал, мөн хүүхэд асрах чөлөөтэй алба хаагчдын цэргийн цолны цалинг 2023.01.01-ний өдрөөс олгож эхлээд байна.

Алба хаагчдын амьдрах нөхцөл, нийгмийн баталгааг хангах зорилгоор тэдний амьдралын нөхцөл байдлыг судлан харьяалах нэгжийн саналыг үндэслэн өөрийн орон байргүй 19 алба хаагчид иж бүрэн тавилгатай гэр олгуулах асуудлыг шийдвэрлүүлсэн.

Шинээр томилогдсон алба хаагчийг туршлагатай алба хаагчид хариуцуулан ажилд нь дадлагажуулах, өдөр тутмын удирдлагаар хангаж, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах талаар харьяа хорих анги, салбар нэгжийн дарга, хүний нөөцийн ажилтнуудад холбогдох үүрэг чиглэлийг тогтмол өгч ажилладаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн бодлого, хэрэгжилт” сэдэвт суурь судалгааны ажлыг Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвтэй хамтран 2023 оны 02 дугаар сараас 2023 оны 05 дугаар сар хүртэл хугацаанд хийж

гүйцэтгэсэн. Судалгааны зорилго нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн өнөөгийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийн, тулгамдсан асуудлыг нээн илрүүлэх, улмаар боловсронгуй болгохтой холбоотой дүгнэлт, зөвлөмж боловсруулахад чиглэгдсэн.

Тус судалгааны ажлын хүрээнд алба хаагчдаас албанаас халшрах хам шинж, сэтгэл ханамжийн түвшин, ажил мэргэжлээс шалтгаалсан өвчлөл, тулгамдаж буй асуудлыг тодорхойлохоор 78 асуулга бүхий асуулгын маягыг бэлтгэн цахимаар хэлбэрээр судалгааг явуулсан. Судалгааны явцад гаргасан дүгнэлтэд үндэслэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох зөвлөмж гаргасан.

ШШГЕГ-ын даргын тушаалаар 58 алба хаагч, 16 ахмад настан, нэгжийн даргын тушаалаар 274 алба хаагч, 52 ахмад настанд амьдралын зайлшгүй шаардлага, нөхцөлийг үндэслэн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон.

Алба хаагчийн хэрэгцээ шаардлагад суурилсан сургалтын арга хэлбэрийг нэвтрүүлж, мэргэшсэн чадварлаг хамт олныг төлөвшүүлэх:

Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/59 дүгээр тушаалаар батлагдсан “Согтуурах, мансуурах донтой хүнд албадан эмчилгээ хийхийг хориглох биеийн хүнд эмгэгийн жагсаалт”-д нэмэлт өөрчлөлт оруулж идэвхтэй хэлбэрийн сүрьеэ өвчтэй хүнд албадан эмчилгээ хийхийг хориглох зохицуулалтыг тусгах саналыг холбогдох газарт уламжлан шийдвэрлүүлэх хүсэлтийг хүргүүлсэн.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэгчийг албадан эмчлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж шийдвэрлүүлэх саналыг 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01/817 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн.

Уг хөтөлбөрийн төсөл Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанд хүргэгдсэн бөгөөд одоогоор хэлэлцэн батлагдаагүй байна.

Шийдвэр гүйцэтгэлийн сул орон тоог нөхөн бүрдүүлэх зорилгоор “Шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт”-ыг 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдөр Дотоод хэргийн их сургуулийн компьютер лабораторийн танхимд Е-тестийн системийг ашиглан сорилын шалгалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж, сорилын шалгалтын оноог үндэслэн тэнцсэн оролцогчдыг ярилцлагын шалгалтад хамруулсан.

Шалгаруулалтад нийт 68 оролцогч бүртгүүлснээс 2 оролцогч шалгалтад ирээгүй, товлосон хугацаанд 66 оролцогчийг бүртгэж, шалгалтад хамруулснаас 33 оролцогч сорилын болон ярилцлагын шалгалтын шаардлага хангасан тул Орон тооны бус мэргэжлийн комиссоос шалгалтын дүнг баталгаажуулж, шийдвэр гүйцэтгэгчийн нөөцийн бүртгэлд тэнцсэн оролцогчдыг бүртгэсэн.

“Шийдвэр гүйцэтгэгчдийн нэгдсэн зөвлөгөөн-IV, Хүний эрх”-ийг 2023 оны 6 дугаар сарын 22, 23-ны өдрүүдэд Дотоод хэргийн их сургуулийн хурлын танхимд амжилттай зохион байгууллаа. Тус зөвлөгөөнд 221 шийдвэр гүйцэтгэгч, 50 ахлах шийдвэр гүйцэтгэгч нийт 271 албан хаагч оролцсон. Уг зөвлөгөөнд Олон улсын шийдвэр гүйцэтгэгчдийн холбоо, БНМУ, ХБНГУ, Эстони улсын шийдвэр гүйцэтгэх

байгууллагын төлөөлөгчид мэндчилгээ дэвшүүлж, хууль тогтоомж, тогтолцооны онцлогийг тус тус танилцуулсан.

Шийдвэр гүйцэтгэгчдийн нэгдсэн зөвлөгөөнд оролцогчдоос шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгох, шийдвэр гүйцэтгэгчдийн эрх зүйн байдлыг дээшлүүлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай “Зөвлөмж”-ийг боловсруулж 2023 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 01/1512 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Шийдвэр гүйцэтгэгчдийн мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, чадавхыг сайжруулах, олон улсын сургалт, хөтөлбөрт хамруулах зорилгоор Сангийн яамнаас авч буй саналын хүрээнд 2025 онд энэ чиглэлээр шинээр хэрэгжүүлэх төслийг Олон улсын хамтын ажиллагааны агентлаг (КОЙКА)-ийн загвараар боловсруулан хүргүүлсэн.

Харьяа шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн нийт ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгчдийн мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг нэг мөр ойлголтоор хэрэгжүүлэх зорилгоор цахим болон танхимын сургалтыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.

ШШГЕГ-ын даргын 2023 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн А/119 дүгээр тушаалаар Шийдвэр гүйцэтгэгчдийн 4-р нэгдсэн зөвлөгөөн, хэлэлцүүлгийг 2023 оны 6 дугаар сарын 22, 23-ны өдөр зохион байгуулсан.

Харьяа шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн нийт ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгчдийн мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг нэг мөр ойлголтоор хэрэгжүүлэх зорилгоор цахим болон танхимын сургалтыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.

2.3. Мэдлэг, ур чадвар, туршлагад суурилсан, улс төрөөс хараат бус, шударга, ил тод, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлэх, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг сайжруулах талаар

2.3.1. Төрийн алба хаагчийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан ажил, үр дүн, төрийн албан хаагчийг давтан сургах хэрэгцээг судлан хэрэгжүүлсэн ажил, үр дүн

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/215 дугаар тушаалаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад 2022-2023 онд зохион байгуулах сургалтын хөтөлбөр”-ийг батлуулан, нийт анги, байгууллагуудад хүргүүлж, сар бүр сургалтын тайлан мэдээг авч нэгтгэн, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаж байна.

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад 2022-2023 онд зохион байгуулах чадавхжуулах сургалтын хөтөлбөр”-ийн хүрээнд дараах мэргэшүүлэх сургалтууд зохион байгуулагдаад байна. Үүнд:

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад 2022-2023 онд зохион байгуулах чадавхжуулах сургалтын хөтөлбөр”-ийн хүрээнд дараах мэргэшүүлэх сургалтууд зохион байгуулагдаад байна. Үүнд:

Захиргааны удирдлагын газар

1. **Архив бичиг хэргийн ажилтнуудын мэргэшүүлэх сургалтад** 18, анхан шатны сургалтад 9, нийт 27 алба хаагчид хамрагдаж, АЕГ-аас гэрчилгээ авсан.

2. **Архив бичиг хэргийн ажилтан нарын /63 алба хаагч/ нэгдсэн сургалтыг цахим хэлбэрээр** 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр, хөмрөг үүсгэгч байгууллагын хамрагдсан;

Хорих ял эдлүүлэх алба

1. **Харуул хамгаалалт гүйцэтгэх ажил эрхэлсэн дэд дарга, цагдан хорих байрны дарга** нарын мэргэшүүлэх сургалт, зөвлөгөөнийг 2023 оны 02 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд;

2. **Ахлах төлөөлөгч, төлөөлөгч** нарын мэргэшүүлэх 16 багц цагийн сургалтыг 2023 оны 04 дүгээр сарын 06, 07-ны өдрүүдэд;

3. **Хүний тоо бүртгэлийн байцаагч, туслах** нарын /63 алба хаагч/ мэргэшүүлэх сургалтыг цахим хэлбэрээр 2023 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр;

4. **Холбоо, мэдээлэл, технологийн инженерүүдийн /19 алба хаагч/** мэргэшүүлэх 8 цагийн цахим сургалтыг 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр;

5. **Ерөнхий жижүүр, ээлжийн дарга** нарын /ерөнхий жижүүр 55, ээлжийн дарга 118 алба хаагч/ мэргэшүүлэх цахим сургалтыг 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдөр;

6. **Холбоочин, дүрс бичлэгийн хяналтын ажилтан** нарын /129 албан хаагч/ мэргэшүүлэх 4 цагийн цахим сургалтыг 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдөр тус тус зохион байгуулсан.

7. **Нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдэд** Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банкттай хамтран Цэцэглэн хөгжсөн, сөрөг нөлөөнд тэсвэртэй Ази, Номхон далайн бүс нутгийг цогцлоох Японы сангийн буцалтгүй тусламжаар "G9198/9221-МОН: Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх" төслийг 2019 оноос амжилттай хэрэгжүүлж байна. Төслийн сургалтын хүрээнд зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан этгээд, баривчлагдсан этгээд, хоригдолд эрх зүйн болон сэтгэл зүйн сургалтыг зохион байгуулах "Сургагч багш" бэлтгэх сургалтыг 2023 оны 09 дүгээр сарын 14, 15-ны өдрүүдэд Дотоод хэргийн их сургуулийн "Эрдэм 2" сургалтын танхимд амжилттай зохион байгууллаа. Сургалтад Хорих ял эдлүүлэх албаны Сургалт, нийгэм, сэтгэл зүйн хэлтэс, Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны Албадан сургалт, хяналтын хэлтэс, аймаг, нийслэл дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих анги, байгууллага, Баривчлах төв, Баривчлах байрны сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, сургалт хариуцсан ажилтан зэрэг нийт 100 алба хаагч хамрагдсан.

8. **Эмч, сувилагч** нарт 2023 оны 05 дугаар сарын 08, 18-ны өдрүүдэд Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл, 429 дүгээр хаалттай хорих анги-Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг хамтран "Тиймээ бид сүрьеэг устгаж чадна сэдэвт" сургалтад нийт 60 эмч, сувилагч, Халдварт өвчин судлалын үндэсний төв ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны албанаас 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдөр, 11 дүгээр сарын 27, 28-ны өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хотын болон хөдөө орон нутгийн 60 эмч нарын дунд "Бэлгийн замаар дамжих өвчнийг эрт илрүүлэх" сэдэвт сургалтыг зохион байгуулсан.

9. **Харуул хамгаалалтын албаны ажилтнуудад** 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр /670 алба хаагч/ Хорих ял эдлүүлэх албаны хурлын заалнаас цахим хэлбэрээр ДХИС-ын ахлах багш, хошууч Э.Өнөболд Хүний эрх болон эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх тухай ойлголт сэдвээр сургалт орсон.

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба

1. **Техник, хяналтын ажилтан** нарын /29 алба хаагч/ мэргэшүүлэх сургалтыг 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр;

Шийдвэр гүйцэтгэх алба

1. **Говь, Хангай, Зүүн бүсийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч** нарт /73 алба хаагч/ “Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд бүрдүүлэх баримт, албан бичиг боловсруулалт, албадан дуудлага, худалдаа, хөрөнгийн шийдвэрлэлт, төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх, сэргээх ажиллагаа, тэжээн тэтгэх үүрэгтэй холбоотой гүйцэтгэх баримт бичигт хийгдэх шийдвэр гүйцэтгэх ажиллагаа” сэдвээр 2022 оны 11 дүгээр сарын 18-25-ны өдрүүдэд цахим хэлбэрээр сургалт зохион байгуулсан;

2. **Ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч** нарт /260 алба хаагч/ “Эд хөрөнгө хураах, үнэлгээ тогтоох ажиллагаа” сэдвээр 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдөр, “Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тулгамдаж байгаа асуудал болон албан хэрэг хөтлөлт” сэдвээр 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр, “Шийдвэр гүйцэтгэлийн бүртгэл хяналтын системд мэдээлэл боловсруулах, баяжилт хийх, цахим сан хөтлөх үйл ажиллагааны чиглэл” сэдвээр 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр цахим хэлбэрээр тус тус сургалт зохион байгуулсан ;

3. **Банкны төлбөр барагдуулах газрын ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч** нарт /31 алба хаагч/ “Албадан дуудлага худалдаа”, “Хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагаа” сэдвээр 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдөр танхимын сургалт зохион байгуулсан;

4. **Ахлах шийдвэр гүйцэтгэгч болон тоо бүртгэлийн ахлах ажилтан, цахим лавлагаа хариуцсан мэргэжилтэн, цахим сан хариуцсан ажилтнуудад** /52 алба хаагч/ шинээр нэвтрүүлж буй “Төлбөр төлөгчийн дансны мэдээлэл солилцох, тогтоол илгээх” арилжааны банкнуудын холбоосыг нэгтгэсэн программын зааварчилгаа, ашиглалтын талаар цахим сургалтыг 2023 оны 04 дүгээр сарын 18-20-ны өдрүүдэд харьяа нэгжийн зохион байгуулж, сургалт зохион байгуулсан;

Санхүү үйлдвэр хөрөнгө оруулалтын газар

1. **Санхүүгийн алба хаагч** нарын /195 алба хаагч/ нэгдсэн сургалт, зөвлөгөөнийг 2023 оны 04 дүгээр сарын 17-21-ний өдрүүдэд зохион байгуулсан;

Хяналт шалгалт, аюулгүй байдлын газар

1. **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын** 2023 оны А/12 дугаар тушаалаар алба, хорих анги, аймаг, нийслэл дэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжийн **дотоод хяналт шалгалт, хөрөнгө, орлогын мэдүүлгийг хариуцсан эрх бүхий албан тушаалтныг** шинэчлэн томилуулж, мөн даргын 2023 оны “Сургалт зохион байгуулах тухай” А/18 дугаар тушаалаар тэдэнд зориулсан цахим мэргэшүүлэх цахим сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулж, уг тушаалын дагуу Хяналт шалгалт, аюулгүй байдлын газраас 01 дүгээр сарын 20-ны өдөр мэргэшүүлэх сургалтыг цахимаар зохион байгуулсан. Сургалтад төв орон нутгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих анги салбар нэгжийн дотоод хяналт шалгалт, хөрөнгө, орлогын мэдүүлэг хариуцсан эрх бүхий **56** албан тушаалтан оролцсон.

2.3.2. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг сайжруулах талаар

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг, Монгол Улсын Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, **Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын дагуу** “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийн нийгмийн хамгааллыг бэхжүүлэх 2021-2024 оны дунд хугацааны хөтөлбөр, төлөвлөгөө”-г боловсруулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/43 дугаар тушаалаар баталж, анги байгууллагад хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээг багцлан дурдвал,

Салбарын эрх зүйн шинэтгэлийг нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн төгөлдөржүүлнэ:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор дараах төрөлжсөн хуулийн төслүүдийг боловсруулан, ХЗДХЯ-нд хүргүүлэн ажиллалаа. Үүнд:

-Иргэн, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслийг 3 хэсэг, 15 бүлэг, 138 зүйлтэйгээр боловсруулж, холбогдох танилцуулгын хамт ХЗДХЯ-нд хүргүүлсэн.

-Эрүү, зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслийг 7 хэсэг, 18 бүлэг, 169 зүйлтэйгээр боловсруулж, холбогдох танилцуулгын хамт ХЗДХЯ-нд хүргүүлсэн.

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тухай хуулийн төслийг 5 бүлэг, 57 зүйлтэйгээр тус тус боловсруулж, хяналтын шатандаа явагдаж байна.

Нийгмийн харилцаа, эдийн засгийн хөгжлийн өөрчлөлттэй үялдуулан салбарын бүтэц, зохион байгуулалт, орон тооны асуудлыг оновчтойгоор шийдвэрлэнэ:

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хорих байгууллагын тогтолцоог бүсчлэн хөгжүүлэх, мансуурах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих түүнтэй тэмцэх урьдчилан сэргийлэх ажил, архи согтууруулах ундааны зохисгүй хэрэглээнээс үүдэлтэй хүн амын эрүүл мэнд нийгмийн аюулгүй байдал, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд Зүүн бүсийн албадан эмчилгээний төв байгуулах болсонтой холбогдуулан нэн шаардлагатай 17 орон тоог харьяа алба, хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн орон тооноос шилжүүлэн авч, Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Зүүн бүсийн албадан эмчилгээний төвийн үйл ажиллагааг эхлүүлж эмчлүүлэгчийн хүлээн авч, эмчилгээ үйлчилгээг үзүүлж байна.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтийг нэмэгдүүлэх, ажил эрчимжүүлэх, алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 53 алба хаагчийг 3 сарын хугацаагаар татан ажиллуулсан.

Ингэснээр нийт 1441 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, 2.1 тэрбум төгрөгийг бодитой биелүүлэн, 440 гүйцэтгэх баримт бичгийг эцэслэн шийдвэрлэж, сард дунджаар 10-14 гүйцэтгэх баримт

бичгийг дуусгавар болгож, тухайн тойргийн бодит биелэлтийг 9.3-24.0 хувь хүртэл нэмэгдүүллээ.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Алсын хараа 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор Дархан-Уул аймаг дахь ШШГГ-445 дугаар нээлттэй хорих ангид цахим хяналт, удирдлагын дэд төвийн үйл ажиллагааг эхлүүлэх болсонтой холбогдуулан харьяа хорих анги, салбар нэгжийн орон тооноос шилжүүлж, хяналтын опероторын 3 орон тоог шинээр батлуулж шийдвэрлүүлсэн.

Мөн хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн ажлын онцлог, ачааллыг харгалзан тус нэгжийн саналыг үндэслэн орон тоог нэгж хооронд эсвэл тухайн нэгж дотор шаардлагатай орон тоонд шилжүүлж өөрчлөх асуудлыг тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна.

Салбарын алба хаагчдын цалин, хөлсний нэмэгдлийг тухайн жилийн инфляцын өсөлт, өндөр хөгжилтэй орны ижил төрлийн байгууллагын түвшинд хүргэнэ.

Алба хаагчдын нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, дэмжлэг үзүүлэх зорилгоор дараах цалин, нэмэгдлийг олгоод байна. Үүнд:

-Аймаг, нийслэлийн төвөөс бусад сум, алслагдсан газарт таван жил тасралтгүй ажилласан алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгож эхэлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар 349 алба хаагчдад 6.8 тэрбум төгрөгийг олгоод байна.

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд хүүхэд асрах чөлөөтэй байгаа алба хаагчдын цолны цалинг олгох асуудлыг шийдвэрлэж, 215 алба хаагчдад 407.6 сая төгрөгийг олгоод байна.

-Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалинг нэмсэнтэй холбогдуулан алба хаагчдын албан тушаалын ангилал, цолны зэрэглэлийг шинэчилснээр офицер бүрэлдэхүүний үндсэн цалин 44 хувь, ахлагч бүрэлдэхүүний үндсэн цалин 48 хувиар тус тус нэмэгдүүлсэн.

-Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023.10.02-ны өдрийн А/335 дугаар тушаалаар албан тушаалын ангилал, цолны зэрэглэлийг шинэчлэн батлуулснаар офицер бүрэлдэхүүний үндсэн цалинг 7.5 хувь, ахлагч бүрэлдэхүүний үндсэн цалинг 13.7 хувиар тус тус нэмэгдүүлж, бусад төрийн цэргийн байгууллагуудын алба хаагчдын цалингийн хэмжээнд хүргэсэн.

-Алба хаагчдын ажлын нэг өдрийн унааны хөнгөлөлтөд 1000 төгрөг, хоолны хөнгөлөлтөд 14.000 төгрөгөөр тус тус тооцож, 10 дугаар сараас эхлэн алба хаагчдын цалин дээр нэмэгдүүллээ.

- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/77 дугаар тушаалын дагуу "Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал" буюу гадаадад суралцагчдын зардлаас гадаадын их, дээд сургуулийн бакалавр, адъюнктур, докторантурт ОХУ-ын их сургуульд суралцаж буй 28 алба хаагчид үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэлэг, цолны мөнгө, унааны зардалд 261.7 сая төгрөг олгосон.

Салбарын алба хаагчдын дүрэмт хувцас, зэвсэг, тусгай хэрэгсэл, тусгай зориулалтын техник хэрэгслийн чанар, стандартыг судлан тогтоож, лаборатори, үйлдвэр байгуулна

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 2023 оны худалдан авах ажиллагааны батлагдсан төлөвлөгөөний дагуу тус ерөнхий газрын даргын 2023.04.12-ны өдрийн “Гэрээ байгуулах эрх олгох тухай” А/88 дугаар тушаалаар 407, 409, 445 дугаар хорих ангиуд, “Газар-Ивээл” ТӨААТҮГ, “Хилийн цэргийн 0288 дугаар анги” ТӨААТҮГ-тай нийт 895.0 сая төгрөгийн цэргийн алба хаагчийн хувцас, хэрэглэлийг үйлдвэрлэн нийлүүлэхээр шийдвэрлэсэн.

Мөн “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу зарим хувцас, хангалтын материалыг нийлүүлэх нээлттэй тендер зарлан, холбогдох журмын дагуу шалгаруулж, шалгарсан 7 аж ахуйн нэгжүүдтэй нийт 895.4 сая төгрөгийн гэрээг байгуулсан.

Тайлант хугацаанд 36 нэр төрлийн 1.2 тэрбум төгрөгийн цэргийн дүрэмт хувцас, хэрэглэлийг алба хаагчдад олгоод байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, алба хаагчдын ажиллаж, амьдрах орчин нөхцлийг сайжруулах арга хэмжээг зохих түвшинд хэрэгжүүлэн ажиллаж байна.

Гурав: Бусад ажил:

3.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх ажлын хүрээнд:

Азийн хөгжлийн банкны ТД56013001 дугаартай Хууль зүйн салбарын хууль зүйн мэдээллийн удирдлагын чадавхыг бэхжүүлэх төсөлд систем шинэчлэн хөгжүүлэх саналыг хүргүүлж, 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн S183733 тоот гэрээг байгуулан ажлыг эхлүүлсэн.

“Хорих болон хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны бүртгэл, хяналтын нэгдсэн систем боловсруулах төслийн баримт бичиг”-ийг боловсруулж, Азийн хөгжлийн банкны ерөнхий координатор, ХЗДХЯ-ны Мэдээллийн технологийн газрын дарга, төслийн удирдагч нарт танилцуулсан.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны мэдээлэл солилцох үйл явцыг өргөжүүлэх, программ хангамжийг боловсронгуй болгох, хөгжүүлэлт хийхэд шаардагдах 250.0 сая төгрөгийн зардлын эх үүсвэр, мөнгөн хөрөнгийг шийдвэрлүүлэн, нээлттэй цахим тендерт шалгарсан “Ухаалаг шийдэл” ХХК-тай гэрээ байгуулж, “Шийдвэр гүйцэтгэлийн бүртгэл хяналтын систем”-ийг шинэчлэн 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдөр үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн бөгөөд 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдөр албан ёсоор хүлээж аваад байна.

Тус ажлын хүрээнд “Фибра” ХХК, “Синк системс” ХХК-уудтай хамтран ажиллах гэрээ байгуулснаар арилжааны банкуудаас төлбөр төлөгчийн дансны мэдээлэл авах, данс битүүмжлэх, данснаас суутгал хийх ажиллагааг цахим хэлбэрээр солилцох холбоосыг нэгтгэсэн программ боловсруулж, арилжааны банкуудтай цахим хэлбэрээр холбогдсон.

Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газартай мэдээлэл солилцох сервисийг Төрийн байгууллагын мэдээлэл солилцох системд нэмэлт хөгжүүлэлт хийж байршуулан үйл ажиллагаанд ашиглаж байна.

Дуудлага худалдааны цахим сан үүсгэх, оролцогчдыг нэмэгдүүлэх зорилгоор “Ютилити вишн” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, программын нэмэлт хөгжүүлэлтийг хийж туршилтаар ашиглаж байна.

ХЗДХЯ-ны харьяа агентлаг, газруудад хэрэгжүүлж байгаа санхүүгийн “И-Аккаунтинг” системийн хөгжүүлэгч талтай 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдөр уулзаж, төлбөр төлөгчийн мөнгөн төлбөрийн шилжүүлгийн талаар тодруулга мэдээллийг өгч, сервис хэлбэрээр мэдээлэл солилцох талаар хэлэлцэж холбогдох мэдээллийг хүргүүлсэн.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтаар Зорчих эрхийг хязгаарлах ялын хяналтын системийн хөгжүүлэлт хийж, хэвийн үйл ажиллагааг хангах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиглэлээр “БиТиЖиТи” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, ялын хэрэгжилтэд ашиглаж байсан хуучин системээс аймаг, нийслэл дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэгдсэн ялтны бүртгэл, хяналтыг шинэ систем рүү шилжүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

Зорчих эрхийг хязгаарлах ялын бүртгэлийн системийг **5000** хүртэл дата өгөгдөл дамжуулж хадгалах боломжтой болгосон.

Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоотой хамтран Зорчих эрхийг хязгаарлах ял эдэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй ялтнуудад зориулан “барил” үсгээр ялтны үүргийг хэвлүүлсэн.

Цахим бугуйвч ашиглах гарын авлага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан ялтны эрх, үүргийг орос, англи, хятад хэлээр хөрвүүлэн QR хэлбэрээр бэлтгэж, цахим орчинд байршуулсан.

Дархан-Уул аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-445 дугаар нээлттэй хорих ангийг түшиглэн хойд бүсийн цахим хяналтын дэд төвийг байгуулж, шинээр 3 орон тоог бий болгосон. Тус дэд төв байгуулагдсантай холбогдуулан Сэлэнгэ, Булган, Орхон, Сэлэнгэ аймгийн Сайхан сум, Сэлэнгэ аймгийн Мандал сум буюу 6 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн зорчих эрх хязгаарлах ялын хяналтын системийг нэгтгэн оруулж, шинэ төрлийн цахим бугуйвчийн тохиргоог J-Link төхөөрөмжөөр хийж, цахим хяналтын системийн ашиглалтын талаар алба хаагчдад сургалт зохион байгууллаа.

Цахим бугуйвч ашиглан хяналт тавих чиглэлээр тооцоо судалгааг гаргаж БНХАУ-ын “Shenzhen Hexun Technology Co.,LTD” компанитай хамтран ажилласан.

“Гэрээ байгуулах эрх олгох тухай” ШШГЕГ-ын даргын 2023 оны А/63 дугаар, Дэд дарга бөгөөд Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны даргын 2023 оны А/10 дугаар тушаалын хүрээнд нийт 127.768.000 төгрөгийн үнэ бүхий DDX-04 загварын 800 ширхэг гарын цахим бугуйвч, 3080 дагалдах хэрэгслэл /оосор, дэлгэц, повер банк/ мөн 10 ширхэг хөлийн бугуйвчийг худалдан авч, зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтэд ашиглаж байна.

Улмаар харьяа газар, хэлтсүүдэд гарын цахим бугуйвч 211 ширхэг, хөлийн цахим бугуйвч 9 ширхэг болон нийт 2078 ширхэг дагалдах хэрэгслийг хуваарилан олгосон.

2023 оны жилийн эцсийн байдлаар зорчих эрхийг хязгаарлах ялын хяналт хэрэгжилтэд нийт 1215 ширхэг гар болон хөлийн цахим бугуйвч ашиглагдаж байгаа бөгөөд нөөц техник хэрэгсэл бүрдүүлсэн болно.

Албаны тоон гарын үсгийн гэрчилгээ олгох, сунгах, түр түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох чиг үүргийг зохицуулах тухай хамтран ажиллах гэрээг “Тридум Э-Секьюрити” ХХК-тай 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан.

ШШГЕГ-ын харьяа хорих анги, шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжүүдийн хэмжээнд УБЕГ-ын харьяа аймаг, сум, дүүрэг, хорооны Улсын бүртгэгч нартай хамтран хоригдолд тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулж, нийт 1025 хоригдолд иргэний тоон гарын үсгийг олгосон.

Төрийн мэдээлэл солилцооны DocX программтай холбогдох ажлын хүрээнд харьяа 61 хорих анги, алба, газар, салбар нэгжүүдийг тоон гарын үсэг ашиглан цахимаар албан бичиг харилцан солилцох мөн төрийн болон төрийн бус бусад байгууллагуудтай цахимаар албан бичиг солилцох боломжийг бүрдүүлж, үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлсэн.

2023 онд Архивын ерөнхий газартай хамтран Төрийн архивын (www.e-document.gov.mn) системийг Тусгай архивын үйл ажиллагаанд шинээр нэвтрүүлсэн. Уг системд 2023 онд 52229 хуудас 443 баримтыг шинээр цахим хэлбэрт шилжүүлж, гүйцэтгэл 40.3 хувьтай хэрэгжсэн. Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажил 2023 оны жилийн эцсийн байдлаар бүрэн хэрэгжсэн.

ШШГЕГ-ын даргын 2023.04.10-ны өдрийн Б/426 дугаар тушаалаар архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх гэрээт ажилтныг томилж, хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулсан.

2023 онд ШШГЕГ-ын цахим хуудсаар дамжуулан онлайн захилга 84, захиалгын хуудсаар 461, нийт 545 иргэн, албан хаагчаас архивын захиалга хүлээн авч, 536 хүсэлтийг шийдвэрлэсэн. Үүнээс лавлагаа-454, цалингийн тодорхойлолт-14, архивын тодорхойлолт-4, 110 иргэн, албан хаагчдад 604 хуудас баримтын хуулбар тус тус олгосон. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад архивын захиалга 19.6 хувиар, архивын үйлчилгээ үзүүлсэн байдал 20.1 хувиар тус тус өссөн үзүүлэлтэй байна.

3.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/126 дугаар тушаалаар “ШШГБ-ын Жендэрийн асуудал хариуцсан дэд зөвлөл”-ийг шинэчлэн баталсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлыг хууль, журмын хүрээнд зохион байгуулан ажиллаж байна.

Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулсан сургагч багш бэлтгэх сургалтад 2020 онд ШШГЕГ-ын ЗУГ-ын ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Б.Шугархүү, 2022 онд 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн Сургалт, хүний нөөц, хэвлэл мэдээлэл, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, дэслэгч Б.Халиун хамрагдаж, гэрчилгээ авсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд ажиллаж байгаа алба хаагчдын 36.9 хувийг эмэгтэй алба хаагчид эзэлж байна.

-Нийт удирдах албан тушаалтны 13.8 хувь нь эмэгтэй;
-Нийт гүйцэтгэх албан тушаалтны 42.1 хувь нь эмэгтэй;
-Нийт туслах албан тушаалтны 32.8 хувь нь эмэгтэй алба хаагч ажиллаж байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар 130 эмэгтэй алба хаагчийг албан тушаалд дэвшүүлэн томилсон бөгөөд удирдах бие бүрэлдэхүүнд 5, ахлах албан тушаалд 47 эмэгтэй алба хаагч /ахлах мэргэжилтэн, ахлах шийдвэр гүйцэтгэгч, ахлах нягтлан бодогч, нийгмийн ахлах ажилтан гэх мэт/, бусад албан тушаалд 78 алба хаагчийг дэвшүүлэн томилсон. Тайлант хугацаанд байгууллагын сул орон тоонд эмэгтэй алба хаагч ажиллах ажлын байрны судалгаанд үндэслэн нийт 147 эмэгтэй иргэнийг сургалтад хамруулж, албан тушаалд томилоод байна.

Эмэгтэй алба хаагчдаас Төрийн дээд шагналаар 64, Хууль зүй, дотоод хэргийн яамны шагналаар 179, ШШГБ-ын шагналаар 421 алба хаагч шагнагдаж, 295 алба хаагчид цэргийн цол олгогдсон.

2023 оны 03 дугаар сарын 07-ны өдөр "Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг тохиолдуулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын "Эмэгтэйчүүдийн зөвлөл" Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөлтэй "Хамтран ажиллах санамж бичиг" байгуулсан. Санамж бичиг байгуулснаар "Дэлхийн мөрөөдлийн сургууль" ТББ, Европ дахь Монгол эмэгтэйчүүдийн холбоо, Солонгос дахь Монгол эмэгтэйчүүдийн зөвлөл болон бусад улс орнуудын эмэгтэйчүүдийн зөвлөлтэй хамтран эмэгтэй алба хаагчид гадаад улс орнуудад туршлага судлах, сурч боловсрох, мэдлэг чадвараа дээшлүүлэх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломж нээгдэж байгаа бөгөөд тус байгууллагын эмэгтэй алба хаагчдын нийгмийн харилцаан дахь манлайлал, оролцоог нэмэгдүүлэх, өөрийгөө хөгжүүлэх боломжийг олгохын зэрэгцээ боловсролын чиглэлээр төсөл хөтөлбөр хамтран хэрэгжүүлж, харилцан мэдээлэл солилцох боломжтой болсон.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон харьяа 55 анги, байгууллагын 2021-2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд жөндөрийн эрх тэгш байдлыг хангах талаар арга хэмжээ оруулсан.

2023 онд "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эмэгтэй алба хаагчдын манлайлал, оролцоо" сэдэвт гэрэл зургийн үзэсгэлэнг дэлгэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагыг төлөөлөн энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн алба хаагчид, авьяас, сонирхлоороо тоорцог урладаг "Үйлчин бүсгүй", урлаг, спортын болон бусад тэмцээн уралдаанд амжилттай оролцсон алба хаагчдын торгон агшнуудыг гэрэл зургийн хальснаа буулгасныг толилуулсан.

ШШГБ-ын хөдөлмөрийн дотоод журамд эмэгтэй алба хаагчид хүүхдээ асрах хугацаанд цэргийн цолны мөнгө олгох талаар тусгасан боловч олгогдохгүй байгаа тул тус асуудлыг ШШГЕГ-ын даргын 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/244 дүгээр тушаалаар 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгосон.

3.3.2023 оны жилийн эцсийн байдлаар 353 алба хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газраар хянуулж, дүгнэлт гаргуулан, 331 алба хаагчийг албан тушаалд томилж, тодорхой шалтгааны улмаас албан тушаалд томилогдоогүй 22 алба хаагч байна.

3.4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд, олон нийтийг хэрэгцээт мэдээ, мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх, алба хаагчдын ажил албаны онцлог, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор нэвтрүүлэг, сурвалжилга, ярилцлага, богино хэмжээний видео, шторк, постер зэргийг бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон сошиал орчинд түгээн ажиллаж байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд тус хуулийн 8 дугаар зүйлд 68 төрлийн мэдээллийг ил тод, нээлттэй болгохоор заасан ба мэдээллийг ил тод болгосон эсэхийг тодорхойлох 98 шалгуур үзүүлэлтийн дагуу холбогдох мэдээллүүдийг cd.gov.mn цахим хуудаст байршуулж, хэрэгжилтийг Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн бөгөөд тус яамны <https://shilen.gov.mn/> сайтад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар 100 хувийн хэрэгжилттэй үнэлэгдсэн.

Мөн харьяа хорих анги, салбар нэгжүүдэд нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах үүрэг чиглэлийг 2023 оны 05/1266 дугаар албан бичгээр хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.

Иргэд, олон нийтийн санаа бодолд дүн шинжилгээ хийх, удирдлагыг мэдээллээр хангах, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээнд нийтлэгдсэн байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчтай холбоотой зэрэг, сөрөг болон нийгэмд өрнөж буй цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийн тоймыг 208 удаа бэлтгэн танилцуулсан.

ШШГЕГ-ын даргын 2021 оны А/42 дугаар тушаалаар баталсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагааг хөгжүүлэх 2021-2024 оны дунд хугацааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж ажиллалаа. Тухайлбал:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын www.cd.gov.mn сайтад 156, фэйсбүүк хуудаст 325, дотоод мэдээллийн самбарт 68 мэдээ мэдээллийг тус тус байршууллаа. Цахим хуудаст давхардсан тоогоор 178568 удаагийн хандалт хийгдсэн байна.

- Байгууллагын албан ёсны cd.gov.mn сайтад “Төрийн үйлчилгээ”, “Албадан дуудлага худалдаа” зэрэг шаардлагатай цэсийг нэмж, тогтмол баяжилт хийж ажилласан.

“Үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолын хавсралт “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-т заасны дагуу байгууллагын цахим хуудаст нийтэлж байгаа мэдээг монгол бичгээр хөрвүүлэн байршуулж хэвшсэн.

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага” фэйсбүүк хуудасны дагагч 2023.12.01-ний өдрийн байдлаар 47023 байгаа бөгөөд тус тоон үзүүлэлтийг өмнөх оны жилийн эцсийн байдалтай харьцуулахад 6415 дагагчаар нэмэгдсэн.

Мөн мэдээ мэдээллийн агуулга, хүртээмж, ач холбогдлыг сайжруулах, гарч болохуйц сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх зорилгоор харьяа хорих анги, салбар, нэгжийн бэлтгэн түгээж буй мэдээ мэдээлэл, контент, нэвтрүүлэг, постер, шторк зэргийг урьдчилан хянаж, редакторлан, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, 269 мэдээг хянаж, редакторлан нийтлэх зөвшөөрөл олгов.

Хэвлэл мэдээллийн төвөөс дотооддоо “Албаны төлөө” нэвтрүүлэг 6, нэвтрүүлэг 4, видео мэдээ 10, шторк 25, постер 86, подкаст 6, фото сурвалжилга 2, ярилцлага 1, нийтлэл 1, сурвалжилга 1 дугаарыг тус тус бэлтгэн олон нийтэд хүргэсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг МҮОНРТ, TV5, TV8 зэрэг телевизийн нэвтрүүлэг 6, зочны ярилцлагын цагт 8, мэдээг 73 удаа давталттайгаар;

“Өдрийн сонин”, “Өнөөдөр”, “Зууны мэдээ”, “Өглөөний сонин” сонинд 30 мэдээ мэдээлэл;

Олон нийтийн сайтуудад нийт сурвалжилга 9, ярилцлага 25, мэдээ мэдээлэл 323 тус тус нийтлүүлсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчтай холбоотой хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээнд нийтлэгдсэн бодит бус, сөрөг мэдээ мэдээлэлд нийт 12 удаа хариу залруулга, давхардсан тоогоор 137 удаа тайлбар мэдээлэл хэвлэл мэдээллийг байгууллагад өгч ажилласан.

3.5.Ногоон хөгжлийг дэмжиж “100 сая мод” хөдөлгөөн өрнүүлэх арга хэмжээний хүрээнд:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нийт бие бүрэлдэхүүн нэгдэж, “100 сая мод” хөтөлбөрийн хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь 100 сая мод тарих хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Хөтөлбөрийн хүрээнд “Мод сөөгний тарьц суулгац ургуулах” цахим сургалтыг Шинжлэх ухааны академийн Газар зүй-Геоэкологийн хүрээлэнтэй хамтран 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулсан. Уг сургалтад нийт 84 алба хаагч хамрагдсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “100 сая мод тарих хөтөлбөр”-ийн хүрээнд чацаргана, мойл, нарс, улиас, хус, агч, буйлс, шинэс, хайлаас, монос, шар хуайс, голт бор зэрэг 1.555.385 модыг тарьж, ургуулж, арчилгаа, усалгааг тогтмол хийж ажилласан.

2023 оны хаврын мод тарилтын ажлын хүрээнд харандаан үрсэлгээ, үрийн үрсэлгээ, тарьц, суулгац, жимс жимсгэнэ, хайлаас, шар хуайс, чацарганы мод зэрэг нийт 647.562 /зургаан зуун дөчин долоон мянга таван зуун жаран хоёр/ ширхэгийг тариалсан.

2023 оны намрын мод тарилтын ажлын хүрээнд тарьц суулгацаар 62,958 ширхэг, үрийн үрсэлгээгээр 11,173 ширхэг, шилжүүлэн суулгасан мод 6717 ширхэг, нийт 80.848 /наян мянга найман зуун дөчин найм/ ширхэг мод тариад байна. 2023 онд нийт 728.410 ширхэг мод тарьсан байна.

Нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн ялтнуудаар мод тарих ажлыг зохион байгуулж улсын хэмжээнд зохион байгуулж 9731 ширхэг модыг тарьж, усалгаа, арчилгаа хийх ажлыг зохион байгуулсан.

Байгууллагын хэмжээнд 413, 417, 423, 433, 439, 457 дугаар нээлттэй, хаалттай хорих ангиуд болон Архангай, Өвөрхангай, Төв, Сэлэнгэ аймаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрууд нийт 58.7 га мод үржүүлгийн газартай болсон.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулсан.

Санамж бичгийн хүрээнд мод тарьж ургуулах, арчлах чиглэлээр алба хаагчдад сургалт зохион байгуулах, Говийн болон Хангайн бүсэд мод тарьж ургуулах, арчлах, хашаа, хамгаалалт барих, ойн зурвас байгуулах зэрэг олон ажлыг хамтран хийж хэрэгжүүлэхээр тогтлоо.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хэрэгжүүлж буй “100 сая мод” хөтөлбөрийн хүрээнд 25 байгууллагатай хамтран ажиллаж байна.

4.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах асуудлаар зөвлөгөө өгч, ажилласан байдал, үр дүн

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Сахилга, ёс зүй хороо нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 27-ны А/183 дугаар тушаалаар батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрэм”, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн А/112 дугаар тушаалаар батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын сахилга, ёс зүйн хороо, салбар хорооны ажиллах журам”-ыг мөрдөн ажиллаж байгаа бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/125 дугаар тушаалаар “Сахилга, ёс зүйн хороо”-г шинэчлэн байгуулж салбар нэгжид мэдээлэл хүргүүлсэн.

Харьяа хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжийн сахилга, ёс зүйн салбар хорооны 2022 оны үйл ажиллагааны дүн, цаашид анхаарч ажиллах зүйлийн талаар ШШГБ-ын төв, орон нутгийн удирдах ажилтны зөвлөгөөн дээр ШШГЕГ-ын Сахилга, ёс зүйн хорооны дарга тодорхой үүрэг, чиглэл өгсөн.

Өгсөн үүргийн дагуу салбар нэгжийн сахилга, ёс зүйн салбар хороод нь “Төрийн албаны тухай хууль”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрэм”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйлчилгээний стандарт”, “Хөдөлмөрийн дотоод журам” Цэргийн албаны нийтлэг дүрэм болон бусад хууль тогтоомж, журам, зааврын хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.

Мөн салбар хороод нь алба хаагчдын мэдлэг, мэргэжлийн ур чадвар, сахилга хариуцлагыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 18-ний өдрийн А/215 дугаар тушаалаар батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад 2022-2023 онд зохион байгуулах сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу харилцаа, хандлага, ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, энэ төрлийн зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр эрх зүй, танин мэдэхүйн сургалт, соён гэгээрүүлэх ажлыг бусад байгууллага, хувь хүмүүстэй хамтран танхимын болон цахим хэлбэрээр зохион байгуулж хэвшүүлсэн.

Тайлангийн хугацаанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд алба хаагчдын гаргасан **1298** сахилга, ёс зүйн зөрчил бүртгэгдсэн бөгөөд “Шүүхийн

шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрэм"-ийн 3.1 дэх хэсэгт зааснаар 632 удаа шалгалт явуулж "Сахилга, ёс зүйн хороо, салбар хорооны ажиллах журам"-ын 3.2 дахь хэсэгт заасны дагуу 446 удаагийн хуралдаан зохион байгуулсан байна.

Алба хаагчдын гаргасан **1298** сахилга, ёс зүйн зөрчил өнгөрсөн онтой харьцуулахад 23.5 хувиар өссөн үзүүлэлттэй /2022 оны тоон судалгаа 992/, үүнээс 90.2 хувь буюу 1171 сахилгын зөрчил, 9.8 хувь буюу 127 ёс зүйн зөрчлөөр бүртгэгдсэн байна.

ШШГЕГ-ын харьяа хорих анги, байгууллагын сахилга, ёс зүйн салбар хороод нь Монгол Улсын Засгийн газрын 2017 оны "Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" 01 дүгээр албан даалгавар, 2018 оны "Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" 258 дугаар тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/105 дугаар тушаалаар батлагдсан "Салбарын албан хаагчдын ёс зүйн үлгэрчилсэн загвар" Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн А/183 дугаар тушаалаар батлагдсан "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрэм", ШШГБ-ын 2023 онд дэвшүүлсэн зорилт зэргийг алба хаагчдад танилцуулах, бие даан судлуулах, үйл ажиллагаандаа дагаж мөрдөх, хэрэгжүүлэх чиглэлийн дагуу сургалтуудыг зохион байгуулж, сахилга, ёс зүйн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухай бүрд нь авч хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг "Дүрэмт хувцас бидний бахархал, дүрмээр өмсөх бидний үүрэг" аяны хүрээнд "Сахилга хариуцлагатай, цэрэгжилт жагсаалч хамт олон" "Цэргийн нийтлэг дүрмүүд", "Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм"-ийн дагуу алба хаагчдыг цэргийн дүрэмт хувцсыг өмсөж хэвшүүлэх, сахилга хариуцлагатай, цэрэгжилт жагсаалч хамт олныг шалгаруулах зорилгоор хорих ангийн хэмжээнд зохион байгуулж ажилласан.

407 дугаар нээлттэй, хаалттай хорих анги Алба хаагчдын сахилга хариуцлага, сонор сэрэмж, цэргийн дүрэмт хувцсыг дүрмийн дагуу цэвэр үзэмжтэй өмсөж хэрэглэх, цэрэгжилт, жагсаалч байдлыг дээшлүүлэх зорилгоор ёс журмын эрүүлийг ангийн даргын зөвлөлийн гишүүдээс томилж алба хаагчид цэргийн дүрэмт хувцсыг холбогдох дүрмийн дагуу өмсөж буй байдалд хяналт тавих, хэрэгжилтийг хангах зорилгоор 7 хоногийн Даваа гараг бүр дүрэмт хувцасны үзлэг хийж, албаны бичиг баримт, биед байх эд зүйлийг шалган ажилласан байна.

409 дүгээр хаалттай хорих анги "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрэм"-ийн заалтын биелэлтийг хангуулах ажлын хүрээнд анги, байгууллагынхаа хэмжээнд сахилга, хариуцлага, ажлын цаг ашиглалт болон алба хаагч хувь хүн нэг бүр албан ажлын өрөө, тасалгааны эмх цэгцтэй байдлыг хангах чиглэлээр дотоод хяналт шалгалтуудыг эрчимжүүлэн ажиллаж Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдын ёс зүй, бие бялдрын бэлтгэлжилтийн түвшнийг тогтоох үзлэгийн гуравдугаар шатны үзлэгт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 409 дүгээр хаалттай хорих ангийн алба хаагчид 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдөр онолын мэдлэг, биеийн жингийн зохистой харьцаа, сэтгэл зүйн бэлтгэл, ёс зүйн байдал, жагсаалын бэлтгэл, 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдөр бие бялдрын бэлтгэлжилтийн шалгалтуудад амжилттай хамрагдсан байна.

Баривчлах төв нийт алба хаагчдад “Сэтгэлийн боловсрол” Төрийн бус байгууллагатай хамтран “Харах өнцгөө өөрчлөх” сэдвээр сургалтыг зохион байгуулж архидаг согтуурах, дам тамхидалтын хор нөлөөг нийт алба хаагчдад сурталчлан таниулах арга хэмжээ зохион байгуулжээ.

Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь Тус газрын Сахилга, ёс зүйн салбар хорооноос Монгол Улсын үндсэн хуулийн өдрийг тохиолдуулан “*Би хуулиа дээдлэгч, ёс зүйтэй алба хаагч*” сэдэвт “АХА” тэмцээнийг алба хаагчдын Үндсэн хуулиа эрхэмлэн дээдлэх, хууль, эрх зүй, сахилга, ёс зүй, цэргийн дүрмүүдийн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор үндсэн хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн сахилга ёс зүйн дүрэм, цэргийн нийтлэг дүрмүүд, цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм, танин мэдэхүйн чиглэлээр бэлдсэн асуултын хүрээнд 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулсан.

“Эерэг харилцаа-шуурхай үйлчилгээ” баннерыг төрөл бүрээр гаргаж цагдан хорих байр, албан конторын угтах үйлчилгээний хэсэгт байршуулан иргэдэд сурталчлан ажилласан.

Алба хаагчдын өдөр тутмын цэргийн албаны харилцааг хэвшүүлэх, цэргийн дүрэмт хувцсыг зөв өмсөж хэрэглүүлэх, иргэд, үйлчлүүлэгчтэй зөв харьцах, эерэг хандлагыг нэмэгдүүлэх, сахилга, ёс зүйн зөрчлөөс ангид байлгах, урьдчилан сэргийлэх, зөрчлийг эрт илрүүлж таслан зогсоох зорилгоор сахилга, ёс зүйн салбар хорооны гишүүд газрын хэмжээнд “**ЁС ЖУРМЫН ЭРГҮҮЛ**”-ээр өдөр бүр ээлжлэн ажиллаж, алба хаагчдад тогтмол хяналт тавин ажилласан байна.

Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар Ёс зүй, сахилгын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, байгууллагын хэмжээнд мөрдөгдөж буй ёс зүй сахилга дэг журмыг сахиулахад чиглэгдсэн эрх зүйн актуудыг алба хаагчдад судлуулах зорилгоор Төрийн албаны тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ёс зүйн дүрэм, үйлчилгээний стандарт, цэргийн дүрэм зэрэг эрх зүйн актуудыг багтаасан 30 асуулт, Авлигын эсрэг хууль, Эрүүгийн хууль, Нийтийн албанд болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль эрх зүйн актуудыг багтаасан 50 асуулт бүхий тест боловсруулж, нийт 182 алба хаагчаас тестийн шалгалт авч дүгнэсэн байна.

“**Хэрэм цамхаг**” УТҮГ алба хаагчдын ажлын хариуцлагыг дээшлүүлэх, зөрчил дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2023 оны 02 дугаар улиралд “**ХИЧЭЭЛ ЗҮТГЭЛ, ЭЕРЭГ ХАРИЛЦАА**” зорилтыг дэвшүүлж, зорилтын хүрээнд: Хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ нэр төртэй биелүүлэх, Эерэг харилцаатай, ёс зүйн зөрчилгүй хамт олон болох, Бүтээгдэхүүний чанар, стандартыг ханган ажиллах дэд зорилтуудыг дэвшүүлэн, зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Мөн алба хаагчдын харилцаа хандлага, ёс зүйг дээшлүүлэх үүднээс “**Эвсэг-Нийтэч хамт олон**” аяныг зохион байгуулж байна.

ШШГЕГ-ын харьяа хорих анги, байгууллагын Сахилга, ёс зүйн салбар хороо нь алба хаагчдын дунд сургалт зохион байгуулах, тэдний албан үүрэг гүйцэтгэлт, сахилга, ёс зүй, хариуцлага, сонор сэрэмжийн байдалд хяналт тавин, илэрсэн зөрчлийг засуулахаар зөвлөмж, дүгнэлт өгөх зэрэг арга хэмжээг авч ажилласан.

Дүгнэлт:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан журам, зааврыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилласан.

Тус байгууллага нь иргэн, алба хаагчдын сонгон шалгаруулах, тэдгээрийн мэдлэг боловсрол, үр чадвар, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, тэдний идэвх санаачилга, урам зоригийг өрнүүлэхэд чиглэсэн удирдлага зохион байгуулалтын олон талт арга хэмжээг тодорхой төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, үр дүнг тооцон ажиллаж байна.

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛ**